



ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 03 сарын 11 өдөр

Дугаар 8/6

Мөрөн сум

Б.Нандин-Эрдэнэд сахилгын
шийтгэл оноох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.3 дахь хэсэг, Хөдөлмөрийн дотоод журмын 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Б.Нандин-эрдэнэ) нь Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлангаар Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д заасныг зөрчсөн нь тогтоогдсон тул албан тушаалын үндсэн цалинг 1 сарын хугацаанд 20 хувиар бууруулах сахилгын шийтгэл оноож хариуцлага тооцсугай.

2.Цалингийн өөрчлөлтийг Хүний нөөцийн системд бүртгэхийг Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн (Г.Хишигбаатар)-т даалгасугай.

3.Албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлж, хуулийн дагуу сахилга хариуцлагыг чангатгаж, алдаа дутагдлаас урьдчилан сэргийлж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Б.Нандин-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Н НАМЖИЛНОРОВ

